



MNR
MONGOLIAN NATIONAL
REPORTING AUDIT

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ

АУДИТОРЫН ТАЙЛАН

**“САТОШИ НАКАМОТО ББСБ ХХК”-ЫН
2025 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭР
ТАСАЛБАР БОЛГОСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3-4
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8-9
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	10-22

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д. Болд-эрдэнэ

АЛБАН ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар, Хан-Уул, 18-р хороо, 58/1,
Гэрлүг Виста хотхон 3 тоот

ХАРИЛЦАГЧ БАНК

Голомт банк
Хаан банк
Хас банк
Худалдаа хөгжлийн банк

АУДИТОР

“Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК

2026 оны 03 дүгээр сарын 31

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ЗахиралДэлгэрсайхан... овогтой...Болд-Эрдэнэ би "...Сатоши Накамото ББСБ....." ХХК-ийн гүйцэтгэх удирдлагын хувьд, ерөнхий нягтлан бодогч ..Отгонбаатар... овогтой Солонго би гүйцэтгэх удирдлагын хувьд ард хавсаргасан 1-ээс хуудас дахь "...Сатоши Накамото ББСБ.." ХХК-ийн санхүүгийн тайлашгуудыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тодруулгуудыг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна. Энэхүү тайланг хүлээн зөвшөөрч батлав.

Гүйцэтгэх захирал



Солонго

Ерөнхий нягтлан бодогч



**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАГНАЛ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
5-р хороо, Самбуугийн гудамж, М Плаза
оффис 6 давхар, 607 тоот
Утас: 99117121; 89601000
И-мэйл: info@mnraudit.mn

2026/03/31 дугаар 26-01/131

Танай _____ - ны дугаар _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК (“Компани гэх)-ийн 2025 оны 12 сарын 31-рх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2025 оны 12 сарын 31-ны өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий ЭТГЭЭДҮҮДИЙН Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилан үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль” -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2026 оны 03 дугаар сарын 31



Ч.БАТТӨМӨР

Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

		/төгрөгөөр/	
	Тодруулга	2024	2025
ХӨРӨНГӨ			
Санхүүгийн хөрөнгө			
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	5,000,000,000.00
	Зээл	6	-
	Факторингийн тооцооны авлага	7	-
	Үүсмэл санхүүгийн хөрөнгө		35,483,618.91
	Хөрөнгө оруулалт		-
	Санхүүгийн хөрөнгийн дүн	5,000,000,000.00	4,666,504,404.63
Санхүүгийн бус хөрөнгө			
	Татвар, НДШ-ийн авлага		-
	Үндсэн хөрөнгө	8	-
	Биет бус хөрөнгө	9	5,748,751.37
	Бусад санхүүгийн бус хөрөнгө	10	-
	Санхүүгийн бус хөрөнгийн дүн		279,360,124.21
			-
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,000,000,000.00	4,972,763,280.21
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
	Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		-
	Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		-
	Бусад эх үүсвэр		-
	Хоёрдогч өглөг		-
	Бусад санхүүгийн өр төлбөр		-
	Санхүүгийн өр төлбөрийн дүн		-
	Татвар, НДШ-ийн өр төлбөр	11	-
	Нөөц /болзошгүй өр төлбөр/		7,477,998.62
	Хойшлогдсон татварын өр төлбөр		-
	Бусад санхүүгийн бус өр төлбөр		-
	Санхүүгийн бус өр төлбөрийн дүн		7,477,998.62
	Нийт өр төлбөрийн дүн		7,477,998.62
Өөрийн хөрөнгө			
	Хувь нийлүүлсэн хөрөнгө	12	5,000,000,000.00
	Өмчийн бусад хэсэг		-
	Хуримтлагдсан ашиг, алдагдал		-
	Нийт өөрийн хөрөнгийн дүн	5,000,000,000.00	5,000,000,000.00
			-
			(34,714,718.41)
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,000,000,000.00	4,965,285,281.59
			-
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,000,000,000.00	4,972,763,280.21

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

		<i>/төгрөгөөр/</i>	
	Тодруулга	2024	2025
Хүүгийн орлого	13	-	436,303,589.73
Хүүгийн зардал		-	-
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО		-	436,303,589.73
Эрсдэлийн сангийн зардал	14	-	(177,000.00)
ЭРСДЭЛИЙН САНГИЙН ДАРААХ ЦЭВЭР ОРЛОГО		-	436,126,589.73
Бусад орлого	15	-	3,893.12
Бусад зардал	16	-	(440,516,990.74)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ		-	(4,386,507.89)
Орлогын татварын зардал	11.1	-	(30,328,210.52)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ТАТВАРЫН ДАРААХ АШИГ		-	(34,714,718.41)

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	/тогроогоор/		
	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31			
НББ-ийн бодлого, тооцооллын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	5,000,000,000.00	-	5,000,000,000.00
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2024 оны 12-р сарын 31	5,000,000,000.00	-	5,000,000,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	(34,714,718.41)	(34,714,718.41)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2025 оны 12-р сарын 31	5,000,000,000.00	(34,714,718.41)	4,965,285,281.59

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	2024	/төгрөгөөр/ 2025
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</u>	-	1,112,437,192.74
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	-	758,190,287.70
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	-	-
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан	-	50,944,800.00
Олгосон зээлийн эргэн төлөлт	-	-
Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	-	-
Бусад	-	303,302,105.04
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</u>	-	3,066,282,055.02
Олгосон зээл	-	2,322,610,000.00
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	-	-
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн	-	-
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	-	-
Ажиллагсад олгосон	-	113,102,540.67
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	55,833,094.99
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Бусад	-	574,736,419.36
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(1,953,844,862.28)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</u>	-	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</u>	-	8,523,900.00
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	8,523,900.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(8,523,900.00)

	2024	2025
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</u>	-	-
Банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	-	-
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад	-	-
<u>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</u>	-	-
Банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрийн зээлд төлсөн	-	-
Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Бусад	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(1,962,368,762.28)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,000,000,000.00	5,000,000,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,000,000,000.00	3,037,631,237.72

1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК нь 2024 оны 05-р сарын 30-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж 9015005220 тоот дугаар бүхий, 7032993 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан. 2025 оны 04-р сарын 26-ны өдөр Д.Болд-эрдэнэ-г компанийн гүйцэтгэх захирлаар томилсон.

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 08-р сарын 07-ний өдрийн 304 дүгээр тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ТЗ 101/813 тоот гэрчилгээ авсан.

Тусгай зөвшөөрлийн дагуу ББСБ дараах үйл ажиллагааг эрхэлж байна.

- Зээл

Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар, Хан-Уул, 18-р хороо, 58/1, Гэрлүг Виста хотхон 3 тоот

2. ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Компанийн санхүүгийн тайлангууд Олон улсын нягтлан бодох бүртгэл болон стандартын зөвлөлөөс гаргасан Санхүү тайлагналын олон улсын стандартуулын (“СТОУС”) дагуу бэлтгэгдсэн болно.

Компанийн санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан болно.

Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

3.1 Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон биет хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

3.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

**3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ
(үргэлжлэл)**

3.3 Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Компани Банк Бус Санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу тус хорооноос гаргасан дүрэм журмыг баримтлан ажиллана. Зээлийн эрсдлийн санг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02-р сарын 25-ний өдрийн 68 дугаар тогтоолоор батлагдсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж тооцдог.

Зээлийн эрсдлийн сангийн тооцоолол, баримталсан хувь хэмжээг ерөнхий бодлогын хэсэг, тодруулгын хэсэгт харуулсан.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

4.1 Санхүүгийн хөрөнгө

Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана.

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдалд тайлагнана.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд хэмжих зорилгоор дараах байдлаар ангилна.

(i) Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгө

Зээл ба авлагууд нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм.

(ii) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө нь арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан аваад богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай хөрөнгө болон анхнаасаа бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгүүдээс бүрдэнэ.

Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилахгүй.

(iii) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

Тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр ба тогтсон хугацаа байхгүй, дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдвсэн хөрөнгө оруулалт болон өмнө дурдсан ангиллуудын алинд ч багтаагүй санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд багтаана.

4. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)**

4.1 **Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

Дараа үеийн хэмжилт

Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийг дараагийн үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

- ✓ Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлаар

Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана. Үр ашигт хүүний аргаар тооцсон хөрөнгө оруулалт болон зээл ба авлагын хүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан
- ✓ Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн; эсвэл бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх

Бодит үнэ цэнийн хэмжилтийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэхээр ангилагдсан санхүүгийн хөрөнгийг зарсан бол бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан бодит үнэ цэнийн тохируулгыг ашиг, алдагдлын тайланд хөрөнгө оруулалтын үнэт цаас борлуулсны олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэн буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэн буурсан гэж үзнэ.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

4.2 Санхүүгийн өр төлбөр

Компанийн өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- ✓ Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ✓ Бусад санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүү байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана.

- Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купон багтана.
- Анхны бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

4.3 Эрсдэлийн сан

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активийн эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу активыг эргэн төлөлтийн хугацаа хэтрэлт болон чанараар хэмжин доорх байдлаар ангилж үлдэгдлээс нь эрсдэлийн сан байгуулна.

Эрсдэлийн сангийн хувь

Хэвийн	Сан байгуулахгүй
Хугацаа хэтэрсэн	5%
Хэвийн бус	25%
Эргэлзээтэй	50%
Муу	100%

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

4.4 Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгө анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгагдана. Анхны өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэсэн хэсгийг оруулсан үед дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг ба ашиглалтын хугацаа дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	Элэгдэл байгуулах жил
Барилга байгууламж	25
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга эд хогшил	5 – 10
Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	2

ААНОАТ-ын тухай хууль шинэчлэгдэж, 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан барилга байгууламжийн ашиглалтын хугацааг 25 жил, компьютер, түүний дагалдах хэрэгслийн ашиглалтын хугацааг 2 жил байхаар шинэчлэн тогтоосон.

4.5 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэн буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэн буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно.

Үнэ цэнийн бууралтыг шалгахдаа хөрөнгүүдийг бүлэглэх ба ингэхдээ бусад хөрөнгүүд болон мөнгө үүсгэгч нэгжүүдээс орох мөнгөн урсгалаас ангид, дангаараа цаашид үргэлжлүүлэн ашигласнаар мөнгөн орох урсгал бий болгох хөрөнгүүдийн хамгийн жижиг бүлэг байхаар бүлэглэнэ.

Тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэ цэн болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль ихээр тооцно.

Хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

4.6 Өөрийн хөрөнгө

Хувцаат капитал

Энгийн хувьцааг өмчөөр ангилж тайлагнасан. Шинээр хувьцаа гаргахтай холбоотой шууд хуваарилагдах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөг хассан дүнгээр нь өмчийн хэсэгт тайлагнана.

Хуримтлагдсан ашиг, алдагдал

Компани үүсгэн байгуулснаас хойш хугацаанд компанид хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэх ба оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

4.7 Шимтгэл, хураамжийн орлого

Хураамж шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлбөр юм. Хураамж шимтгэлийн орлогыг тухайн зээлийг олгосон үед орлогоор хүлээн зөвшөөрдөг.

4.8 Үйл ажиллагааны зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдид хуваарилснаас бусад шалгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

4.9 Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, авлага болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Зээлтэй холбоотой ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг алдагдлын тайланд санхүүгийн зардалд багтаан тайлагнана. Бусад ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлын цэвэр дүнгээр тайлагнана.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

4.10 Түрээс

Түрээсийн гэрээний хүрээнд эзэмшиж буй ашиглах эрх бүхий хөрөнгө болон түүнтэй холбоотой түрээсийн өр төлбөрийг түрээсийн хугацааны эхэнд шаардах эрх бүхий хөрөнгө болон богино хугацаат эсвэл урт хугацаат өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэх ба богино хугацаанд буюу 12 сарын хугацаатай эсвэл бага үнэ цэнтэй түрээсээс бусад түрээсийн хувьд уг зарчмаас чөлөөлөгдөхгүй. Түрээсийн гэрээний дагуу олж авсан шаардах эрх бүхий хөрөнгийг тус хөрөнгөөс хүртэж буй эдийн засгийн өгөөжтэй нь уялдуулан түрээсийн хугацаанд системтэйгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Богино хугацаат буюу 12 сарын хугацаатай эсвэл бага үнэ цэн бүхий түрээсийн хувьд түрээсийн үүрэг хариуцлагыг санхүүгийн зардлыг хассан цэвэр дүнгээр нь богино хугацаат өр төлбөрийн хэсэгт харуулдаг. Түрээсийн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн зардал гэсэн хоёр хэсэгт ангилна. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид ашиг алдагдлын тайланд тусгах ба тайлант хугацаа бүрийн хувьд өр төлбөрийн үлдэгдэлд тооцогдох тогтмол хугацааны хүүг тооцоолох шаардлагатай. Урт хугацаат түрээсийн гэрээний дагуу олж авсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаанд эсвэл түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ.

4.11 Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

4.12 Татварын бүртгэл

Орлогын албан татвар

Орлогын албан татварын тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан эсвэл ирээдүйд хэрэгжих хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн татварын зардал болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн жил эсвэл өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэснээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм.

4. НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

4.12 Татварын бүртгэл (үргэлжлэл)

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй. Ирээдүйд татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үед бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

4.13 Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөл уг хүн нь:

- a) Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай
- b) Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй
- c) Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- a) Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын гишүүд байх
- b) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх
- c) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх
- d) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох
- e) Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн “ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө”-нд хамаарах.
- f) Байгууллагад (a)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх
- g) (a)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын гол удирдлагын багийн гишүүн байх
- h) Байгууллага эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах

“САГОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

/төгрөгөөр/

5. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

	2024	2025
Касс дахь мөнгө	-	-
Банкин дахь мөнгөн хөрөнгө	5,000,000,000.00	3,037,631,237.72
	5,000,000,000.00	3,037,631,237.72

6. ХАРИЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

Зээлийн ангилал	2024		2025	
	Зээл	Эрсдэлийн сан	Зээл	Эрсдэлийн сан
Хэвийн	-	-	1,590,026,548.00	-
Анхаарал хандуулах	-	-	3,540,000.00	(177,000.00)
Хэвийн бус	-	-	-	-
Эргэлзээтэй	-	-	-	-
Муу	-	-	-	-
Дүн	-	-	1,593,566,548.00	(177,000.00)
			1,593,566,548.00	1,593,389,548.00

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХӨДӨЛГӨӨН

	2024	2025
Сангийн эхний үлдэгдэл	-	-
Тайлант хугацаанд нэмж байгуулсан	-	177,000.0
Тайлант хугацаанд буурсан	-	-
Сангаас хаасан зээл	-	-
Сангийн эцсийн үлдэгдэл	-	177,000.0

/төгрөгөөр/

7. ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮГИЙН АВЛАГА

Хүүний авлага нь харилцагчидад олгосон зээлийн хүүний авлага болон банкин дахь богино хугацаат хадгаламжийн хүүний авлагын дүнг илэрхийлнэ.

	2024	2025
Хэвийн хүүний авлага	-	35,171,661.80
Хугацаа хэтэрсэн хүүний авлага	-	311,957.11
Торгуулийн хүүний авлага	-	-
Хадгаламжийн хүүний авлага	-	-
	-	35,483,618.91

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	2024	Өсөлт	Бууралт	2025
Анхны өртөг:				
Барилга байгууламж	-	-	-	-
Машин тоног төхөөрөмж	-	-	-	-
Тээврийн хэрэгсэл	-	-	-	-
Тавилга эд хогшил	-	-	-	-
Компьютер бусад хэрэгсэл	-	8,523,900.00	-	8,523,900.00
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-	-
	-	8,523,900.00	-	8,523,900.00
Хуримтлагдсан элэглэл:				
Барилга байгууламж	-	-	-	-
Машин тоног төхөөрөмж	-	-	-	-
Тээврийн хэрэгсэл	-	-	-	-
Тавилга эд хогшил	-	-	-	-
Компьютер бусад хэрэгсэл	-	2,775,148.63	-	2,775,148.63
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-	-
	-	2,775,148.63	-	2,775,148.63
Цэвэр дүн:				
Барилга байгууламж	-	-	-	-
Машин тоног төхөөрөмж	-	-	-	-
Тээврийн хэрэгсэл	-	-	-	-
Тавилга эд хогшил	-	-	-	-
Компьютер бусад хэрэгсэл	-	8,523,900.00	(2,775,148.63)	5,748,751.37
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-	-
	-	8,523,900.00	(2,775,148.63)	5,748,751.37

Тайлант онд 2ш компьютер болон 1ш принтерийг 8,523,900 төгрөгөөр олж бэлтгэсэн.

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД– 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. **БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

/төгрөгөөр/

	2024	Өсөлт	Бууралт	2025
Анхны өртөг:				
Тусгай зөвшөөрөл	-	279,360,124.21	-	279,360,124.21
	-	279,360,124.21	-	279,360,124.21
Хуримтлагдсан элэглэл:				
Тусгай зөвшөөрөл	-	-	-	-
	-	-	-	-
Цэвэр дүн:				
Тусгай зөвшөөрөл	-	279,360,124.21	-	279,360,124.21
	-	279,360,124.21	-	279,360,124.21

10. **БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ**

	2024	2025
Бусад	-	21,150,000.00
	-	21,150,000.00

Бусад санхүүгийн бус хөрөнгө нь захиралтай холбоотой 15,000,000.00 төгрөгийн дараа тайлан тооцооны үлдэгдэл болон 6,150,000.00 төгрөгийн урьдчилж төлсөн зардал байна.

11. **БУСАД ӨГЛӨГ**

	2024	2025
Цалингийн өглөг	-	-
ААНОАТ-ын өглөг	-	17.77
ХХОАТ-ын өглөг	-	7,477,980.85
НДШ-ийн өглөг	-	-
	-	7,477,998.62

12.1 **ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ**

	2024	2025
Орлогын албан татварын зардал	-	30,328,210.52
	-	30,328,210.52

12. **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ**

	2024	2025
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000,000,000.00	5,000,000,000.00
	5,000,000,000.00	5,000,000,000.00

“САТОШИ НАКАМОТО ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД– 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

		<i>/төгрөгөөр/</i>	
		2024	2025
13.	ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО		
	Зээлийн хүүний орлого	-	64,630,454.61
	Харилцах дансны хүүний орлого	-	303,282,105.04
	Хадгаламжийн хүүний орлого	-	-
	Нэмэгдүүлсэн хүүний орлого	-	68,391,030.08
		-	436,303,589.73
14.	ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ		
	Зээлийн эрсдэлийн сангийн зардал	-	177,000.00
		-	177,000.00
15.	БУСАД ОРЛОГО		
	Зээл хураамж, шимтгэлийн орлого	-	-
	Бусад орлого	-	-
	Тэнцлийн гадуурх данснаас орсон орлого	-	-
	Бусад	-	3,893.12
		-	3,893.12
16.	БУСАД ЗАРДАЛ		
	Арилжааны зардал	-	-
	Ханш, үнэлгээний өөрчлөлтийн гарз	-	-
	Банкны шимтгэлийн зардал	-	765,200.00
	Цалингийн зардал	-	140,841,236.25
	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал	-	17,335,777.91
	Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал	-	-
	Зарлал, сурталчилгаа, маркетингийн зардал	-	32,827,720.26
	Элэгдэл, хорогдлын зардал	-	2,775,148.63
	Түрээсийн зардал	-	29,700,000.00
	Харилцаа холбооны зардал	-	4,942,318.40
	Түлш шатахуун, тээврийн зардал	-	-
	Зочин төлөөлөгч, баяр ёслолын зардал	-	2,195,672.00
	Хандив	-	-
	Бусад	-	1,295,460.00
	Үйл ажиллагааны бусад зардал	-	207,838,457.29
		-	440,516,990.74
17.	БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА		
	Болзошгүй өр төлбөрт тайлангийн хугацаанд эрх, үүрэг нь үүссэн хараахан хэрэгжээгүй байгаа буюу үнийн дүн эсвэл цаг хугацааны хувьд тодорхой бус байгаа зүйлсийг багтаасан ба тайлант хугацаанд болзошгүй өр төлбөр үүсээгүй болно.		
18.	ТАЙЛАГНАЛЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ		
	Тайлагналын өдөр буюу 2025 оны 12 дугаар сарын 31 болон энэхүү тайланг баталгаажуулсан өдрийн хоорондын хугацаанд ямар нэгэн залруулагдах болон үл залруулагдах гүйлгээ гараагүй болно.		